# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр Дугаар 76 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 366,398,971.00 (гурван зуун жаран зургаан сая гурван зуун ерэн найман мянга есөн зуун далан нэгэн) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Ховд Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Нямдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

0000153

D:\Huraldaanii material\2019 on\2019.03.05 №4\Togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
......76...... дугаар тогтоолын хавсралт

## Ховд Их Сургуулийн 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг (мян.төгрөг) |
|---|---|---|
| **Барилга байгууламж** | | |
| 1 | Хичээлийн 1-р байрны гадна фасадын засвар | 10,000.0 |
| 2 | Хичээлийн 1-р байрны гадна шилэн хаалга, дотор самбар хийх | 2,500.0 |
| 3 | Хичээлийн 1-р байрны анги танхим, бөхийн өргөө, спорт заалны засвар, | 18,000.0 |
| 4 | Хичээлийн 1-р байрны Лекцийн заалны засвар | 5,000.0 |
| 5 | Музейн урсгал засвар | 3,000.0 |
| 6 | Музейн сантехникийн ажил | 336.0 |
| 7 | Бахархлын танхим засварлах | 1,000.0 |
| 8 | Хичээлийн 1-р байрны цайны газрын засвар | 500.0 |
| 9 | Хичээлийн 1-р байрны номын сангийн засвар | 4,980.4 |
| 10 | Хичээлийн 1-р байрны сантехникийн засвар | 28,381.3 |
| 11 | Их нууруудын хотгорын туршилт судалгааны суурингийн хашаа барих | 5,000.0 |
| 12 | Хичээлийн 2-р байрны анги, танхимын засвар, | 12,000.0 |
| 14 | Хичээлийн 2-р байрны Лекцийн заалны засвар | 5,000.0 |
| 15 | Хичээлийн 2-р байрны цайны газрын засвар | 500.0 |
| 16 | Гадна тохижилтын ажил | 5,000.0 |
| 17 | Усан оргилуур | 2,500.0 |
| 18 | Дадлагын суурингийн засвар | 2,500.0 |
| 19 | Оюутны 1, 2-р байрны засвар | 11,737.8 |
| 20 | Оюутны байрны сантехникийн засвар | 16,846.0 |
| 21 | Баян-Өлгий салбар сургуулийн урсгал засвар | 5,619.8 |
| 22 | Хичээлийн 1-р байрны коридорын паркетан шалны засвар | 12,630.5 |
| **Бүгд дүн** | | **153,031.8** |
| **Тээврийн хэрэгсэл** | | |
| 23 | Суудлын авто машин 1 ширхэг, суудлын тоо-5, хөдөлгүүрийн багтаамж 4000сс хүртэл, улсын дугаар аваагүй | 70,000.0 |
| **Бүгд дүн** | | **70,000.0** |
| **Биет бус хөрөнгө** | | |
| 24 | Нягтлан бодох бүртгэлийн програм | 8,000.0 |
| **Бүгд дүн** | | **8,000.0** |
| 25 | **Тоног төхөөрөмжийн бүгд дүн** | **100,127.2** |
| 26 | **Тавилга эд хогшлын бүгд дүн** | **6,040.0** |
| 27 | **Номын фондын баяжилтын бүгд дүн** | **29,200.0** |
| **НИЙТ ДҮН** | | **366,398.971** **(гурван зуун жаран зургаан сая гурван зуун ерэн найман мянга есөн зуун далан нэгэн)** |